

2020 ОНЫ ЗУРГААДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Уур амьсгалын тойм

Зургаадугаар сарын агаарын температурын ОЖД нь 17-20 градус дулаан байдаг. Зургаадугаар сард агаарын дундаж температур сүүлийн 3 жилд ОЖД-аас дулаан байсан ба 1997 онд хамгийн дулаан буюу ОЖД–аас 2⁰С-аар дулаан байсан байна. Харин 2009-2012 онуудад ОЖД–аас 0.5-1.0⁰С-аар хүйтэн байсан ба 2010 онд хамгийн хүйтэн 6-р сар болсон байна.

Зургаадугаар сард ОЖД –аар аймгийн нутгаар 42-59 мм хур тунадас ордог. Зарим жил ОЖД – аас хэд дахин их болон бага хур тунадас орох тохиолдол цөөнгүй байдаг. Тухайлбал, 1980-1982, 1987, 1992,1995-2007, 2017-2019 онуудад ихэнх сумдын нутгаар дунджаас харьцангуй бага хур тунадас орсон бол 1983-1986,1990-1991, 1993-1994, 2008-2009, 2011-2016 онуудад зарим нутгаар олон жилийн дунджаас ахиу хур тунадас орсон байна.

Зургаадугаар сард салхины хурд 15 м/с-ээс дээш ширүүсч, шороон шуурга шуурах тохиолдол олон жилийн дунджаар 3-5 удаа ажиглагддаг.

ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД–ийн орчим буюу 15-20 градус дулаан байна. (**зураг1**)


Нэгдүгээр арав хоногийн дунд, хоёрдугаар арав хоногийн эхэн болон дунд, гуравдугаар хоногийн дунд үеэр өмнөх үеэсээ хүйтэрнэ, харин нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн эхэн үеэр өмнөх үеэсээ 2-5⁰С – аар дулаарна.

Энэ сард бүх сумдын нутгаар ОЖД-аас ахиу буюу 43-60 мм хур тунадас орох төлөвтэй байна. (**зураг2**)

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр ихэнх сумдын нутгаар бороо орох төлөвтэй.


Салхи нэгдүгээр арав хоногийн эхэн, дунд, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн эхэн болон дунд үеэр зарим сумдын нутгаар 10-12 м/с хүртэл ширүүсэх төлөвтэй.

6-р сарын агаарын температурын урьдчилсан мэдээ



(зураг1)

6-р сарын хур тунадасны урьдчилсан мэдээ



(зураг2)